



Өдөрт Гурван Удаа

МАГТААЛ ХҮНДЛЭЛ Бид Их Эзэнийг магтан хүндлэхдээ баяртай байдаг.

Унших Зүйл

Даниел 6; *Зөнчид ба Хаад*, х. 539-548.

Цээжлэх Ишлэл

"[Даниел] Их Эзэнд залбиран, талархал өргөж байлаа" (Даниел 6:10).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Есүсийн найзууд өдөр бүр Их Эзэнтэй ярьдаг гэдгийг мэдэх болно.

Их Эзэн тэдний залбирлыг сонсдог гэдэгт итгэлтэй байх болно.

Залбирлаараа дамжуулан Их Эзэнтэй баяр гунигаа хуваалцдаг болно.

Гол Санаа



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Даниелтай хамт ажилладаг хүмүүс Даниелд атаархан хаанаас өөр хэн ч хэн нэгэнд залбирч болохгүй бөгөөд залбирсан хүн байвал арслангийн үүрэнд хаяж өгөх тушаалыг хаанаар гаргуулжээ. Хааны хүмүүс Даниелыг харж байсан ч тэрээр өдөрт гурван удаа Их Эзэнд залбирсан хэвээр байв. Тэгээд хааны хүмүүс түүнийг хаанд хэлж хаан түүнийг арслангийн үүрэнд хаяж өгөх болов. Даниел Их Эзэнд маш их итгэдэг байсан. Их Эзэн Даниелыг хамгаалахаар өөрийн элч нараа илгээхэд хаан Даниелын Эзэнийг ямар их хүч чадалтай болохыг харжээ.

Энэ бол магтаал хүндлэлийн тухай хичээл

Бид залбирч, Их Эзэний гарт бүхнийг даатгавал тэр нь Түүнийг хүндэлж буй хэрэг юм. Их Эзэн Даниелтай хамт байх болно гэдгийг тэр өөрөө мэдсэн шиг та ч бас үүнд итгэж болно.

Багшийн Баяжуулалт

"Зөнчний дайснууд Даниелын зарчмыг бат мөрддөг байдлыг өөрсдийн төлөвлөгөөний амжилттай тал болгон тооцоолжээ. Тэд түүний дүр төрхийг зөв тооцоолсон. Харин

НАЙМ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Өдөрт Гурван Удаа</i> <i>Б. Арслангийн Үүрэнд</i>	байхгүй байхгүй
* Залбирал ба Магтаал*	10 минут	83-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	шар эсвэр бор өнгийн ариун цэврийн цаас, утас, сунадаг резин, цонхны зураг, Библи
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>Залбирлын Хаана, Юу, Хэзээ</i>	<i>Бяцхан хүүхдүүд Түүнийг магт дууны ном, самбар, шохой</i>
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Анхилуун Сав</i>	жижиг сав эсвэл нэг удаагийн аяга, даавууны өөдөс, сунадаг резин, хатсан навч эсвэл цэцэг, лимон, жүрж, алимны хэрчиж хатаасан зүсэм, үнэртэн

Даниел тэдний зарлигаар дамжуулан гарах хорт зорилгыг мэдсэн ч, өөрийн замналаа тодорхой өөрчлөөгүй юм.... Залбирлын цаг болоход тэрээр өрөө рүүгээ явж, цонхоо Иерусалимын зүгт том гэгч нь нээн, сурсан зангаараа өөрийн залбирлаа Мөнхийн Эзэний өмнө өргөлөө. Тэр өөрийн энэ үйлдлээ нуун далдлах гэж оролдоо ч үгүй. Хэдийгээр тэр Бурханд итгэх үнэнч байдал нь ямар үр дүнд хүргэхийг

мэдэж байсан ч, түүний сүнс огтхон ч эргэлзэж, итгэл нь буураагүй юм" (Зөнч ба Хаад, х. 540, 542).

Өрөөний зохион байгуулалт

Тавдугаар хичээлийг хар. 3, 7-р хичээл дээр хэрэглэж байсан сандал нөмрөгсөн бүтээлгийг арслангийн үүр хийхэд ашигла. Бүх хүүхдүүд орж чадахуйц багтаамжтай байх ёстой.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.

1

Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Өдөрт Гурван Удаа

Хэлэх: **Миний хийснийг дагаад хий. 2 гараа алдлан тэгш зогс.** Хэлсэн зүйлдээ хариулах хугацааг олгоорой: **Өглөө эрт, Их Эзэн биднийг хайрладаг. Өглөө эрт гэсэн утгаас бид юуг санаж Их Эзэнд талархаж чадах вэ?** (Өглөөний цай, нар, шувуу жиргэх, шинэ өдөр, шөнийн хамгаалалт гэх мэт).

Баруун гараа дээш нь өргө. (Яг л нар тэнгэр дээр нүүж байгаа юм шиг). Хэлэх: **Их Эзэн биднийг үд дунд бас хайрладаг. Үд дунд гэсэн утгаас бид юуг санаж Их Эзэнд талархаж чадах вэ?** (Өдрийн хоол, сургуулийн завсарлага, өдрийн дулаан, амрах цаг гэх мэт).

Баруун гараа зүүн гар уруугаа нүүлгэн. Яг л өдөр дуусч байгаа мэт. Хэлэх: **Их Эзэн биднийг шөнө ч хайрладаг. Унтах цаг болоход тэр хайрласаар л байдаг. Шөнө гэдгээс бид юуг санаж Их Эзэнд талархаж чадах вэ?** (Миний зөөлөн ор, миний гэр бүл, шөнө тэвэрч унтах чихмэл тоглоом, өдрийн турш хамгаалалт гэх мэт). Хэлэх: **Одоо хамтдаа хэлцгээе: Өглөө, өдөр, шөнийн төлөө тандаа талархаж, Их Эзэн минь.**

Багатгах нь

Хүүхдүүдийн хариулыг сонсоорой: **Та нар өдөрт хэдэн удаа залбирдаг вэ? Даниел өдөрт гурван удаа залбирч байсан гэдгийг мэдэх үү? Өглөө, өдөр бас орой. Өдөр болон шөнийн туршид хэзээ ч хамаагүй Их Эзэн бидний залбирлыг сонсох дуртай байдаг. Бид залбирлаараа Түүнийг хүндэлж байдаг бөгөөд Түүнд хайртайгаа харуулж байдаг юм. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:**



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Арслангийн Үүрэнд

Хүүхдүүдийг 2 бүлэг болгон нэг бүлгийг нь 2 эгнээ болгон өөд өөдөөс нь харуулан зогсоо. Тэдний дундуур хүн явах зай байхад л хангалттай. Хэлэх: **Арслангийн тухай гардаг зарим Библийн түүхийг санаж байна уу?** (Самсон, Давид, Ноа, Даниел). **Арслан ямар дуу гаргадаг вэ? Тэд гэртээ тэжээж болох амьтад гэж үү? Жинхэнэ арслантай маш ойр байхыг та нар хүсэж байна уу? Одоо та нарын тал нь арслан болно. Харин тал нь арслангийн эгнэж**

зогссон эгнээн дундуур гарна. Энэ арслангууд архирч чадах боловч тэд хүмүүст хүрч чадахгүй юм. Учир нь хүмүүс бие биеийнхээ төлөө залбирч байгаа шүү дээ. Хугацаа олгоод дуусах үед нь солбин тоглож нөгөө хэсэг хүүхдүүдийг арслангуудын эгнээн дундуур гаргаарай.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой. Архирч байгаа арслангуудын дундуур гарахад хөгжилтэй биш байна уу? Жинхэнэ арслангуудын дунд явж байна гэдгээ яаж мэдэрсэн бэ? Библийн түүхэнд нэг хүн арслангуудтай хамт бүх л шөнөжин байдаг. Тэгээд юу болсон гэж та нар бодож байна? Тийм ээ, тэр залбирсан юм. Их Эзэн түүний залбирлыг сонссон. Тэр Их Эзэнтэй хаана ч ярьж болно, бүр арслангийн үүрэнд хүртэл шүү дээ. Санагтун:



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

Намайг дагаад хэлээрэй.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

- "Их Эзэнд магтаалаа өргөцгөөе" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 219*)
- "Есүстэй өрнүүлсэн бяцхан яриа" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 227*)
- "Би Есүстэй ярьдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 228*)
- "Залбирал" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 231*)
- "Тэнгэр элч" 2-р бадаг (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 121*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй. Асуух:

Өнөөдрийн түүх дээр хүмүүс хэрхэн Их Эзэнийг хүндэлж байсан бэ? (Шаббат өдрийн үйл ажиллагааг бүү хязгаарлаарай).

Хандив

Хэлэх: **Бид өргөлөө хуваалцсанаараа Их Эзэнийг хүндэлж чадах бөгөөд бусад хүмүүс ч Их Эзэнтэй залбирлаараа ярьж болдог гэдгийг мэдэх болно.**

Залбирал

Хэлэх: **Бид мөн дуу дуулснаараа Их Эзэнтэй ярьж болдог гэдгийг мэдэх үү? Бүгдээрээ Түүнд залбирлаа дуулцгаая.** "Би залбирна" гэдэг дууг дуулаарай. (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 229*)

*Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- шар эсвэл бор өнгийн ариун цэврийн цаас
- утас
- сунадаг резин
- цонхны зураг
- Библи

Бүх хүүхдүүд багтахаар арслангийн үүр хийнэ (Өрөөний зохион байгуулалтыг хар). Цонх байдаг ханыг цэвэрлэж хүүхдүүд суух бөгөөд эсвэл ханан дээр цонхны зураг зураад хүүхдүүд хажууд нь сууж болох юм.

Юуны өмнө, ариун цэврийн цаасаа урт урт хэсэг болгон зүсээд хамтад нь нэг үзүүрийг нь резин эсвэл утсаар боогоорой. Хүүхэд бүрт нэгийг хийж өгөөрэй. Энэ нь арслангийн зогдор болох юм.

Зүсмэл цааснуудыг алган дээрээ тавиад унжсан хэсгийг нь гарын араар оруул. Тэгвэл үс шиг харагдана. Нөгөө гараа ариун

цэврийн цаастай гаран дээрээ тавьж хуруунууд чинь шүд шиг харагдах ёстой. Арслан амаа нээж хааж байгаа юм шиг гараа бас нээж хаагаарай. Хүүхдүүдэд энэ бүхнийг хийж үзүүлбэл тэд арслангийн дүрд хэрхэн тоглохоо мэдэх болно.

Түүхийг ярьж эсвэл уншиж өгөх

Даниел Дариус хааны туслагч байсан ба бусад туслах болон ханхүү нар Даниелд ихэд дургүй байв. Тэд хоорондоо нууцаар "Бүгдээрээ түүнийг сайн харж байя. Тэгээд түүнийг хэрэгт оруулая. Буруу зүйл хийж байхад нь бариад авъя" хэмээн шивнэлдэнэ [шивнэх].

Тэд Даниелыг харж тагнасаар. Тэд Даниелыг гэрт нь харна, ажил дээр нь харна, гэвч тэд ямар ч буруу зүйл олсонгүй.

"Надад нэг шинэ санаа байна" гэж нэг ханхүү хэлээд тэд хаанд энэ тухайгаа хэлэхээр явлаа. Бүгдээрээ хааны өрөөнд орцгооё. [Хүүхдүүдийг хааны өрөөнд оруулах].

"Дариус хаан түм наслатугай. Таныг шинэ хууль гаргахад тань энэ их сайхан санаа болох байх гэж бодож байна. Ирэх гуч хоногт хүмүүс зөвхөн танд залбираг" гэж хааны туслахууд, ханхүү нар хэлээд залбирсан хэн нэгэн байх аваас

арслангийн үүрэнд шидэгдэн өгөх болно гэдгийг сануулжээ.

Дариус хаан инээмсэглээд өөрийнхөө өмнө хүмүүсийг мөргүүлэх дуртай байв. Энэ хууль сайхан сонсогдсон байх л даа. Тэгээд тэр "Бичиж ав. Энэ бол хууль. Бид хуулиа өөрчилж чадахгүй" гэв.

Ханхүү нар ордонг орхиод ихэд хөгжилдөн "Одоо бид Даниелыг барьж чадна. Тэр Их Эзэнээсээ өөр хэнд ч залбирахгүй" гэлцэнэ. Тэд Даниелыг маш сайн мэдэж байв. Түүнийг хааны үгийг дагахгүй гэдгийг ч, Их Эзэндээ залбирсаар байх болно гэдгийг ч мэдэж байлаа.

Тэд ордоноос гарсныхаа дараа хаашаа явсан гэж бодож байна? Мэдээж, Даниелын гэр рүү. [Цонхон дээр эсвэл зурсан цонхон дээр очих].

Даниел гэртээ хийдэг зүйлээ л хийж суув. Түүний юу хийж байсныг хэн нэгэн харуулж чадах уу? [Хүүхдүүдийг цонхны хажууд өвдөглүүлэх]. Библид [Библиэ нээгээд] "Тэр өдөрт гурван удаа өвдөг сөгдөн Их Эзэнд залбирч Түүнд талархал өргөж байжээ" гэж байна. (Даниел 6:10).

Мэдээж ханхүү нар Даниелыг Их Эзэндээ залбирч байхыг нь хараад бүгд ордон луу яаран [Хааны өрөөнд эргэн орох] "Даниел таны үгийг анзаарах ч үгүй байна. Тэр Их Эзэндээ забирсаар байна" гэжээ.

Хаан үүнийг сонсоод ихэд харамсан ханхүү нар яагаад ийм хууль гаргуулсныг одоо мэдэж авлаа. Гэвч хаан аль хэдийн хуулиа гаргаад баталчихсан. Тэр хэлсэндээ хүрэх ёстой, баталсан хуулиа өөрчилж болохгүй байв. Хуулинд зааснаар Даниелыг арслангийн үүрэнд хийх ёстой байлаа.

Дариус хаан Даниелтай хамт арслангийн үүр рүү явж байхдаа ихэд гунигтай байлаа. Учир нь тэр Даниелд хайртай бас түүнийг гэмтээхийг ч хүсэхгүй байсан юм. Хаан хууртжээ.

Даниелыг арслангийн үүрэнд орохоос өмнө хаан түүнд "Их Эзэн тань чамайг хамгаалах болтугай" гэлээ.

Даниелын Их Эзэн түүнийг хамгаална



гэдэгт хаан итгэж байсан эсэхийг би мэдэхгүй ээ. Тэр Даниелд хайртай учраас хэн нэгэн түүнийг арслангийн савраас авраасай хэмээн хүсчээ.

Арслангийн үүрэнд ороод Даниел ямар байсан гэж бодож байна? Энд байгаа арслангийн үүрэндээ орцгооё. *[Хүүхдүүдтэй хамт үүр рүү ор. Тэдний нүдийг аниулах хэрэгтэй].*

Энд харанхуй байна уу? Тийм ээ, арслангийн үүр харанхуй гэж би бодож байна. *[Хүүхдүүд нүдээ нээж болно].* Үүдэн дээрээ энэ маш том чулуутай учраас арслангууд гарч чадахгүй. Даниел ч зугтаж чадахгүй. Яг энэ үүр шиг дургүй зүйлийнхээ тухай бод. Энэ нь муухай үнэртэй ч байж болох юм.

Одоо бүгдээрээ хэсэг үсийг гар дээрээ тавин арслан мэт архирч байхдаа энэ гарыг арслан гэж бодоорой. *[Хүүхдүүдэд арслангийн үсийг өгөөд яаж зүүхийг нь хэлж өг].* Та нар том арслан шиг архирч чадах уу? Эсвэл жижиг асрлан шиг аяархан уу? Та нар өлссөн мэт архирч чадах уу?

Тэр шөнө арслангууд архирсан гэж бодож байна уу? Магадгүй тэд маш их архирсан боловч Даниелд огтхон ч хүрээгүй юм. *[Хүүхдүүд архирах ба бие биедээ гар хүрэхгүй].* Магадгүй тэд архираагүй ч юм бил үү? Магадгүй тэд тэр шөнө маш намуухан байсан ч юм бил үү? Яагаад гэдгийг нь мэдэх үү? Есүс тэр арслангийн үүр рүү элч нараа илгээсэн юм. Тэд Даниелыг харгалзан арслангуудын амыг хаажээ. *[Хэрвээ хэн нэгэн хүүхэд архираар байвал түүнд энэ амаа хаалттай архирах хэцүү болохыг хэлж арслангууд тэр шөнө яагаад тийм намуухан байсныг тайлбарла.]*

Даниел арслангийн үүрэнд байхдаа залбирсан гэж бодож байна уу? Тэр залбирсан гэдэгт би бүрэн итгэлтэй байна. Та нар ч бас тэнд байсан бол залбирах байсан уу? Та нар юу гэж гуйх байсан бэ?

Дариус хаан Даниелаас ч илүү санаа зовж байсан байх. Даниел Их Эзэнтэй ярьж чадах боловч хаан яаж гэдгийг нь мэдэхгүй шүү дээ. Бүх л шөнөжингөө Дариус хаан шаналжээ. Тэр оройн зоогоо ч идсэнгүй. Хөгжим ч сонсохыг хүссэнгүй.

Унтаж ч чадахгүй байлаа. Эцэст нь, өглөө болж нар гарахад хаан хувцаслан арслангийн үүр рүү гүйв.

"Даниел, Их Эзэн чинь чамайг арслангаас аварч чадав уу?" гэж хаан асуухад "Өө хаантан минь. Их Эзэн маань элчээ илгээн арслангуудын амыг хаалаа" гэж Даниел хэллээ.

Дариус хаан ихэд баярлан түүнийг нүхнээс гаргав. Хүн бүр Даниелыг харна. Магадгүй Даниел тэдний дундуур явсан байх *[Хүүхдүүд өрөөгөөр тойрон явах].* Тэр арсланд самардуулаа ч үгүй, арслангууд түүнд огтхон ч хүрээгүй байв. Энэ бол гайхамшиг. Хаан ихэд баяртай байлаа. Тэр ордондоо буцан улсынхаа бүх хүмүүст захидал бичлээ. Юу гэж бичсэнийг нь мэдмээр байна уу?

"Даниелын Бурхан бол үнэн Бурхан. Энэ Бурхан бол хүмүүсийг хамгаалж мөн аварч чадна. Тэр Даниелыг арслангуудаас аварлаа" гэв.

Хаан Даниелын Бурханыг зүгээр ч нэг агуу Их Эзэн гэж бодоод зогсоогүй хаантан өөрөө ч Бурхантай ярьдаг болсон байх гэж би бодож байна.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Хүмүүс яагаад Даниелыг арсланд өгөхийг хүссэн бэ? Яагаад Даниел хэнд ч харагдаж мэдэгдэхгүйгээр чимээгүйхэн эсвэл амандаа залбираагүй вэ?**

Яг Даниел шиг та нар ч мөн зоригтой байна гэж бодож байна уу? Яагаад? Даниелд зоригтой байхад хэн тусалсан гэж бодож байна вэ? Санацгаая:



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Библиэ нээгээд Даниел 6-г гарган **"Өнөөдрийн бидний үзсэн түүх Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээд сэдвийг чангаар уншаарай.

Хэрэгтэй зүйлс:

Библи

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Даниел ямар хүн байсан бэ? Хааны хүмүүс Даниелыг хэрхэн урхинд оруулсан бэ? Тэд хаанаар юу хийлгэхийг хүссэн бэ? Даниел хааны үгийг дагасан уу? Их Эзэний үгийг дагасан уу? Даниел юу хийсэн бэ? Хаан хуулийг өөрчилж чадсан уу? Хаан юу мэдэрсэн бэ? Даниелд юу тохиолдсон бэ? Их Эзэн Даниелыг хэрхэн хамгаалсан бэ?**

Цээжлэх Ишлэл

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библиэ нээгээд Даниел 6:10-г гарган **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээд ишлэлийг чангаар унш. **"Даниел**

Их Эзэнд залбирч, талархал өргөж байлаа" Цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.




Даниел Дээшээ заах.
Их Эзэнд



залбирч Гараа хавсраад толгойгоо бөхийлгөх.



талархал өргөж байлаа. Дээшээ харан гараа алдлах.



Даниел 6:10 Алгаа нийлүүлээд ном мэт дэлгэнэ.

Хүүхэд болгоныг цээжилтэл нь давтаарай.

3

Хичээлээ Заах

Залбирлын Хаана, Хэзээ, Юу

Хэрэгтэй зүйлс:
 Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана
 самбар
 шохой эсвэл маркер

Хэсэг

Хүүхдүүд арслангийн үүрэнд орж нуугдана. Асуух: **Хаана байгаа газраа та нар Есүст залбирч чадах уу? Их Эзэн чамайг хаана байгааг чинь харж чадах уу? Тэр чиний залбирлыг сонсож чадах уу?**

Их Эзэн биднийг хаа ч байсан хардаг. Биднийг хэзээ ч залбирсан Тэр үргэлж сонсож байдаг. Яг Даниелын хийсэн шиг бидэнд ч залбирлын онцгой газар

хэрэгтэй. Түүний онцгой газар хаана байсан бэ? Тийм ээ, Тэр өрөөндөө цонхоор хараад залбирсан юм.

Хэлэх: **Гэртээ залбирч болох янз бүрийн газрыг ол. Би тэднийг самбар дээр бичих болно. Хүүхдүүдээс нэг нэгээр нь асуу. Залбирах үедээ Есүстэй юу гэж ярьдаг тухайгаа надад яриач. Би тэднийг ч мөн бичих болно. Хүүхдүүдээс нэг нэгээр нь асуу.**

Бататгах нь

Хэлэх: **Бүгдээрээ одоо Есүст хаана залбирдгаа харцгаая.** Самбар дээрх залбирлын хариуг унш. **Чи Есүст юуны төлөө залбирдаг вэ?** Самбар дээрээс залбирлын хариуг унш. **Чи хэзээ залбирч болох вэ? Тогтсон цаг байдаггүй бөгөөд Есүстэй ярьж эхлэх өдөр сайхан байдаг.**

Даниел хэдэн удаа залбирдаг байсныг чи мэдэх үү? Даниел гэртээ залбирч байхдаа юу мэдэрч байсан гэж бодож байна? Мөн арслангийн үүрэнд ч гэсэн? Чи залбирахдаа юу мэдэрдэг вэ? Яг Даниел хийж байсан шиг чи ч мөн өдөр бүр залбирч байхыг хүсэж байна уу? Их Эзэн чиний залбирлыг сонсох дуртай. Тэр бол чиний найз.

Хэлэх: **Бүгдээрээ залбирлын тухай дуу дуулъя.** "Өдөр бүрийн залбирал" дууг дуул (*Бяцхан хүүхдүүд Түүнийг*

магтана, № 232) эсвэл залбирлын тухай өөр ямар нэгэн дуу ч байж болно.

Хэлэх: **Өнөөдрийн хичээлийн гол санаагаа хамтдаа хэлцгээе:**



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

4

Хичээлээ Хуваалцах нь

Анхилуун Сав

Юуны өмнө, жимсийг нарийхан хэрчээд шарах шүүгээнд хийж хатаагаарай. Асуух: **Чиний хамгийн дуртай үнэр юу вэ? Сарнай болон шинэхэн талхны үнэр ямар сайхан гэж. Анхилуун сайхан үнэртэй олон зүйл байдаг юм. Библид бидний залбирал нь Их Эзэний хувьд анхилуун сайхан үнэртэн гэж бичсэнийг мэддэг үү?** (Илчлэлт 5:8)

Чамд ээж, аав, эмээ чинь ямар нэгэн үнэртэн цацаж өгөхөд чи дуртай байдаг уу? Сайхан үнэртэй зүйлийг үнэртэх сайхан шүү дээ. Их Эзэн бидний залбирлыг сонсохдоо баяртай байдаг бөгөөд бидний залбирал Түүний хувьд яг л анхилуун үнэртэн шиг юм.

Одоо бид зарим нэгэн үнэртэй зүйлийг үнэрлэж үзье. Энэ бидэнд залбирахыг санагдуулах ба Их Эзэний хувьд бидний залбирал бол анхилуун үнэртэн л гэсэн үг.

Хүүхэд бүрт жижиг сав эсвэл хуванцар аягыг өгөөд хэрчсэн жимс, навч, цэцэг зэргээс савандаа юу хиймээр байгааг нь өөрсдөөр нь сонгуул. Хүүхдүүд саваа дүүргэснийх нь дараа саванд нь бага зэрэг үнэртэн хийж өгөөрэй. Саван дээр нь мөнгөн цаас тавиад резинээр амыг нь боо. Савыг болгоомжтой сэгсрэх ба ингэвэл хийсэн үнэртэн чинь доторх зүйлүүдтэй нь

сайтар холигдох болно. Хүүхдүүдээр жижиг даавууны хэсэг дээр үнэртэн цацуулаад олон төрлийн үнэр үнэрлэхэд нь урамшуулаарай.

Багатгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж олгоорой: **Бид Есүст залбирахад Тэр юу мэдэрдэг бол? Бид залбирлаараа дамжуулан Есүст юу гэж хэлж чадах вэ? Чи Есүстэй хаана ярилцаж болох вэ? Мөн чи Есүстэй хэзээ ярьж болох вэ?**

Гэртээ хариад та нар гэр бүлийнхэнтэйгээ, хөрштэйгөө эсвэл найзтайгаа хийсэн зүйлээ хуваалцаарай. Бидний залбирал Их Эзэний хувьд анхилуун үнэртэн байдгийг тэдэнд хэл. Тэр үүнд их дуртай. Бид залбирснаараа Их Эзэнийг хүндэлж байдаг гэдгийг ч мөн найздаа хэлж өгөөрэй. Найздаа залбирахад нь тухтай бөгөөд өөрийн гэсэн газар олоход нь туслаад анхилуун үнэртэй саваа тавьж өг эсвэл анхилуун үнэртэй саваа өөрийн залбирлын газраа ч тавьсан болно. Санацгаая:

Хэрэгтэй зүйлс:

- жижиг сав эсвэл нэг удаагийн аяга
- даавууны дугуй хэсэг
- сунадаг резин
- хатаасан цэцэг
- лимон, жүрж, алимны хэрчмэл
- үнэртэн



Бид залбирлаараа Их Эзэнийг хүндэтгэж байдаг.

Хичээлийн Хаалт

Хэлэх: **Одоо бүгдээрээ Их Эзэнд зориулж залбирлын дуу дуулъя. "Залбирлаа шивнээч" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 233) дууг эхлүүлээрэй.**

Өдөрт Гурван Удаа

Унших Зүйл

Даниел 6;
Зөнчид ба Хаад,
х. 539-548.

Цээжлэх Ишлэл

"Даниел Их
Эзэнд залбиран,
талархал өргөж
байлаа" (Даниел
6:10).

Гол Санаа

**Бид
залбирлаараа
Их Эзэнийг
хүндэтгэж
байдаг.**

Та найз нартайгаа ярилцах дуртай юу? Яг л Даниелын хийсэн шиг та ч бас, хаана ч, хэзээ ч, юуны ч тухай найз нартайгаа ярьж байгаа юм шиг Есүстэй ярьж болно шүү дээ.

Шинэхэн суусан Дариус хаан үйлчлэгч нараараа хүрээлүүлэн сууж "Зарлиг буулга. Би улсаа 120 хэсэгт хуваах гэж байна. Хэсэг бүрт захирагч байх болно. Даниел тэдний нэг болно" гэв.

Зарим ханхүү болон захирагчид Даниелыг сонгогдсонд ихэд дургүйцэн "Түүнийг ялд унагаая. Бид түүнийг буруу зүйл хийж байхад нь барьж авах болно" гэж өөр хоорондоо шивнэлдэнэ.

Тэд өдөр бүр Даниелыг сайтар ажсаар байсан боловч түүнээс ямар ч бурууг олж харсангүй.

"Надад нэг санаа байна" гэж нэг ханхүү хэлээд бусдыгаа уруу татан бүгд атаа хорслоор дүүрч хааны ордон руу явлаа.

"Хаантан та түм насалтугай. Бидэнд нэг санаа байна. Энэ таныг шинэ хуулиа хийхэд ч нэмэр болох юм. Гурав хоногийн турш хэн ч, юунд ч залбирч болохгүй бөгөөд тэд зөвхөн танд л залбирна. Хэрвээ таны үгийг дагаагүй нэг хүн байх аваас түүнийг арслангийн үүрэнд хаяж өгье" гэж ханхүү болон захирагчид хэлээд хааны өмнө сөгдөн суужээ.

Дариус хаан өмнөө олон хүнийг сөгдүүлэхийг хүсэж байсан учраас хуулийг зөвшөөрөн баталчихав.

Захирагчид инээлдэн "Хүн бүр Даниелыг цонхныхоо хажууд өдөрт гурван удаа залбирдаг гэдгийг мэддэг билээ. Одоо бид түүнийг барьж Даниелаас салах боломжтой боллоо"

гэлцэнэ.

Захирагчид удалгүй Даниелыг Их Эзэндээ залбирч байхыг хараад хаан дээр яаран ирж "Даниел өөрийн Их Эзэндээ залбирч байна" гэж мэдээллээ.

Дариус хаан нөгөө баталсан хууль

нь Даниелыг хорлох арга байсныг сая л мэджээ. Хаан Даниелд их хайртай байсан ч баталсан хуулиа дагах ёстой байв. Тэр Даниелыг арслангийн нүхэнд хаях ёстой байлаа. "Их Эзэн чинь чамайг хамгаалах болтугай" гэж Даниелд хаан хэлэхэд цэргүүд түүнийг авч явав.

Дариус хаан бүх л шөнөжингөө Даниелд санаа зовж удалгүй нар мандахад арслангийн үүр лүү

яаран гүйж "Даниел, Их Эзэн чинь чамайг хамгаалав уу?" гэж асуулаа. Харин Даниел "Хаантан минь, Миний Их Эзэн элчээ илгээн арслангуудын амыг хаалаа" гэж хэлжээ.

Дариус хаан Даниелыг арслангийн үүрнээс гаргуулаад улсынхаа хүн бүрт хандан захиа бичлээ. "Даниелын Их Эзэн бол цорын ганц үнэн билээ. Их Эзэн нь түүнийг арслангуудаас хамгаалсан ба Тэр Эзэн Бурхан нь хэнийг ч аварч хамгаалах болно" гэж захиа бичлээ.

Хааны зарлиг болон арслангууд Даниелын залбирахыг зогсоож чадаагүй бөгөөд Их Эзэн нь түүнийг залбирлыг сонсчээ. Тэр чиний залбирлыг ч бас сонсдог юм шүү.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ хөдөлгөөний дагуу хийгээрэй.

Даниел Их Эзэнд ...Дээшээ заах. залбиранГараа атгаад толгойгоо бөхийлгөнө.
талархал өргөж.....Дээшээ харан гараа байна.
Даниел 6:10Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Даниел 6-г хамтдаа уншаад асуух нь: Хааны хүмүүс Дариус хааныг хэрхэн ятгасан бэ? Даниел залбирахын тулд хаашаа явж байсан бэ? Их Эзэн Даниелыг хэрхэн хамгаалсан бэ? Тэгээд Дариус хаан Их Эзэний тухай юу гэж хэлсэн бэ?

Хүүхэд тань залбирахад онцгой газар олохын төлөө залбираарай.

Даваа

Шаббат хичээл дээр хийсэн анхилуун саваа өөр хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Библийн түүхээ ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. Бидний залбирал Их Эзэний хувьд яг л чихэрлэг гоё үнэртэнтэй адил тооцогддог гэдгийг тэдэнд сануул. (Илчлэлт 5:8).

Их Эзэнд талархах зүйлсийн жагсаалтыг гаргахад хүүхдэдээ туслаад өдөр бүр залбирлынхаа өмнө шинэ зүйл нэмээрэй.



Мягмар

Арслангийн үүрэнд Даниел залбирч байсан тухай ярьж асуух нь: Их Эзэнд залбирч болохгүй гэсэн хууль гарсан бол чи яах вэ? Чи тэгвэл юу хийх байсан бэ?

Залбирч болох 3 газар, залбирах 2 үе, Есүстэй хуваалцах 4 зүйлийг тоолоод нэрлэхэд нь хүүхдэдээ тусал. Ямар ч үед Есүстэй ярьж болдог Их Эзэнд таларх.

Лхагва

Арслангийн тухай өгүүлсэн номыг хамтдаа үзээд асуух нь: Арслангийн үүрэнд шөнөжингөө Даниел юу мэдэрсэн гэж бодож байна? Тэр өөрийг нь хамгаалж байгаа элч нарыг харсан гэж бодож байна уу?

Хүүхдийнхээ нүдийг нь боож гараас нь хөтлөөд гадаа гарч алх. Дараа нь асуух нь: Би чамайг унагаахгүй гэдэгт итгэхэд чамд хэцүү байсан уу? Амархан байсан уу? Их Эзэнд итгэхэд Даниелд хэцүү эсвэл амархан байсан уу?



Пүрэв

Өөрийнхөө залбирлын хариунаас хүүхдэдээ ярьж өгөөрэй. Хүүхдээрээ ч мөн нэгийг яриул. Залбирлын дэвтэр хөтөлж хүүхдийн тань залбирал хэзээ яаж биелэснийг тэмдэглээрэй.

Баасан

Гэр бүлтэйгээ хамтран Библийн түүхийг жүжигчилэн ширээ эсвэл сандлыг том бүтээлгээр бүтээн арслангийн нүх хий.

Гэр бүлээрээ тойрон гар гараасаа хөтөлж сөгдөн суугаад хамгийн их талархаж байгаа зүйлийнхээ төлөө Есүст талархаарай.